

## **ЦАГДААГИЙН АКАДЕМИЙН МАГИСТР, ДОКТОРЫН СУРГАЛТЫН ЖУРАМ**

### **Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмын зорилго нь тус академид магистр, докторын сургалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Цагдаагийн академийн “Магистр, докторын сургалтын журам нь” /цаашид “Сургалтын журам” гэх/ Боловсролын, Дээд боловсролын, Цагдаагийн байгууллагын тухай хууль, Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам (БСШУ-ны сайдын 2007 оны 6-р сарын 07-ны өдрийн “Дүрэм, журам батлах тухай” 187 тоот тушаал), Цагдаагийн академийн дүрэмд үндэслэнэ.

1.3.Тус академийн магистр, докторын сургалт /цаашид “Магистрантур, докторантур” гэх/ нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, олон улсын нийтлэг жишиг, шинжлэх ухаан, технологийн дэвшилд үндэслэн хууль зүйн шинжлэх ухааны салбараар суралцагсдад сургалт, эрдэм шинжилгээ, шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагуудад мэргэжлийн өндөр түвшинд ажиллах, судалгааны ажил гүйцэтгэх, бие хүн өөрийгөө нээн хөгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, соёл төлөвшүүлэхэд чиглэнэ.

### **Хоёр: Сургалтын орчин, шаардлага**

#### **А.Удирдлага**

2.1.Магистр, докторын сургалтыг нэгдсэн удирдлагаар хангах, сургалтын үйл ажиллагаанд хяналт тавих, магистрын зэрэг хамгаалуулах зөвлөл байгуулах ажлыг зохион байгуулах, мэдээллийн холбогдох сан бүрдүүлэх үүргийг Академийн хэмжээнд Эрдэм шинжилгээний хэлтэс хариуцан хэрэгжүүлнэ.

2.2.Академийн магистр, докторын сургалтад хичээл заадаг багшийн кредитийн үнэлгээг тухайн түвшний сургалтын онцлог, хөдөлмөр зарцуулалт, мэргэжлийн ур чадвар, эрдмийн зэрэг, цолд дүйцүүлэн тогтооно.

2.3.Магистр, докторын сургалтыг Цагдаагийн академийн мэргэжлийн тэнхимд түшиглэн зохион байгуулна.

#### **Б. Багш**

2.4.Магистрын сургалтын мэргэжлийн хичээлийн, докторын сургалтын багш нь бүгд тухайн чиглэлээр докторын зэрэгтэй байна.

2.5.Академи багш нарыг судалгаа шинжилгээний ажил эрхлэх боломж, нөхцөлөөр хангах, багшийн зүгээс уг ажлыг үндсэн ажлын хүрээнд эрхлэн гүйцэтгэнэ.

#### **В. Магистрант, докторантын удирдагч**

2.6. Академийн захирлын тушаалаар магистрант, докторантын элссэн хичээлийн жилд багтаан суралцагч нэг бүрээр харьяалах тэнхим, эрдэм шинжилгээний ажлын удирдагч /цаашид "Удирдагч" гэх/-ийг томилон баталгаажуулна.

2.7. Докторын ажил /цаашид "Диссертац" гэх/-ын сэдвийн онцлогийг харгалзан хамтарсан удирдагчийг томилж болно.

2.8. Удирдагч нь магистрын ажил, диссертацийн сэдэв тодорхойлох, суралцагчийн судалгааны ажлын төлөвлөгөө боловсруулах, судалгааны ажил хийх болон магистрын ажил, диссертац бичих явцад тодорхой хуваариар мэргэжлийн зөвлөгөө өгч, хяналт тавих, ажлын агуулгыг хэсэг бүрээр болон бүхэлд нь дүгнэх, удирдсан магистрын ажил, диссертацийг хамгаалалтад оруулах зөвшөөрөл өгөх, эрдэм шинжилгээний болон судалгааны семинар зохион байгуулж суралцагч уг семинарт судалгааны ажлынхаа үр дүнг илтгэн хэлэлцүүлж байх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

Иймд удирдагч суралцагчийн судалгааны ажлын талаар үнэн зөв тодорхойлолт гаргаж, түүнийхээ хариуцлагыг хүлээнэ.

2.9. Магистрант, докторантын удирдагч нь докторын зэрэгтэй, тухайн чиглэлээр 5-аас цөөнгүй жил сургалт, эрдэм шинжилгээний байгууллагад багшилсан буюу судалгааны ажил эрхэлсэн, сүүлийн 5 жилд 3-аас цөөнгүй эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж мэргэжлийн үнэлгээнд үндэслэн шилж сонгон хэвлэдэг (реценз бүхий) мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн байна.

Докторын удирдагч энэ шаардлагаас гадна тухайн чиглэлээр сүүлийн 3 жилд 1-ээс цөөнгүй нэг сэдэвт зохиол буюу эрдэм шинжилгээний бүтээл хэвлүүлсэн байвал зохино.

2.10. Удирдагч нэг хичээлийн жилд 3-аас илүүгүй магистрант, 2-оос илүүгүй докторантын судалгааны ажлыг удирдана.

Шинжлэх ухааны докторын хувьд танхимын сургалтын ачаалал, судалгааны сэдвийг харгалзан 4-өөс илүүгүй магистрантын судалгааны ажлын удирдагчаар ажиллахыг зөвшөөрч болно.

2.11. Академийн магистр, докторын сургалтанд оролцдог гадны байгууллагын судалгаа шинжилгээний ажил эрхэлдэг ажилтныг удирдагчаар томилж болно. Энэ тохиолдолд тухайн салбар эрх зүйн чиглэлээр удирдагчаар ажиллуулах үндсэн багш, гадны байгууллагын тооны харьцаа 2:1-ээс хэтрэх ёсгүй. Мөн гадны байгууллагын нэг удирдагчид 1 докторант, 2-оос илүүгүй магистрантын ажил удирдах зөвшөөрөл олгоно.

2.12. Магистрант, докторанттай зохих шаардлагын түвшинд ажиллахгүй байгаа удирдагчийг өөрчлөх саналыг Магистр, докторын сургалт хариуцсан нэгжийн дарга Академийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн шийдвэрлүүлж болно.

### **Г. Номын сан, мэдээллийн бааз**

2.13. Академийн номын сан магистрант, докторант нарт тусгайлан үйлчилдэг уншлагын танхимтай байна.

2.14. Суралцагч суралцах хугацаандаа Академийн дүрэм, дотоод журмын хүрээнд номын сан, компьютерийн лаборатори, интернетээр үйлчлүүлэх эрхтэй.

## **Гурав. Сургалтын үйл ажиллагаа**

### **3.1 Элсэлт**

3.1.1. Магистрантур, докторантурын элсэлтийг Академийн захирлын тушаалаар байгуулагдсан комисс БСШУЯ-наас олгосон сургалтын чиглэл, хяналтын тоонд багтаан хичээлийн жилд 1 удаа (9-р сарын 20-ны дотор) зохион байгуулна.

3.1.2.Цагдаагаас бусад алба, нэгжээс элсүүлэн суралцуулах ажилтан, иргэний тоо, сургалтын төлбөрийн хэмжээг Цагдаагийн академи жил бүр тусгайлан тогтоож болно.

3.1.3.Эрдэм шинжилгээ судалгааны тодорхой бүтээлтэй, эрдэм шинжилгээний ажил хийх, их, дээд сургуульд багшлах дадлага, авьяас, сонирхолтой, магистрын зэрэгтэй хүнийг докторантурт, бакалаврын зэрэгтэй хүнийг магистрантурт уралдаант шалгалтаар элсүүлнэ.

3.1.4.Нууцын зэрэглэлд хамаарах сэдвийг нийтэд зарлахгүйгээр албаны журмаар мэдээлж, элсэлт авна.

3.1.5.Магистрантурт элсэхээр хүсэлтээ гаргасан хүний бакалаврын зэрэг бүхий боловсролын үнэмлэхэд бичигдсэн хос мэргэжилд эрх зүй хамаарч байвал мэргэжил, мэргэшүүлэх хичээлийн багтаамж нь 80 кредитээс багагүй байна.

3.1.6.Магистрантур, докторантурт элсэхийг хүсэгч дараах материалыг бүрдүүлж товловсон хугацаанд элсэлтийн комисст ирүүлнэ. Үүнд:

- Өргөдөл
- Биеийн байцаалт (төрийн албан хаагчийн 1-р маягтаар)
- Иргэний үнэмлэх (баталгаажуулсан хуулбар)
- Өмнөх түвшний боловсрол (бакалавр, магистр)-ын зэрэг эзэмшсэн диплом, хавсралт (баталгаажуулсан хуулбар)

Тайлбар: Магистрантурт элсэх хүний бакалаврын дипломын үнэлгээний голч 3.0 (80%), докторантурт элсэгчийн магистрын дипломын голч 3.3 (85%)-аас тус тус дээш байна.

- Суралцагчийн ажлыг зохицуулан түр чөлөөлөхийг зөвшөөрсөн харьяа байгууллагын тодорхойлолт
- 4х3 хэмжээтэй фото зураг 2%
- Элсэлтийн хураамж төлсөн баримт

Докторантурт элсэгч дараах материалыг нэмж ирүүлнэ.

- Оюуны бүтээлийн жагсаалт
- Сонгосон сэдвийн чиглэлээр бичсэн реферат

3.1.7.Цагдаа, дотоодын цэрэг, ШШГБ-ын ажилтнуудын хувьд бакалавр, магистрын зэргийн боловсрол эзэмшснээс хойш тухайн байгууллагад 2-оос доошгүй жил үр бүтээлтэй ажилласан байна.

3.1.8.Цагдаагийн академийг бакалаврын зэрэгтэй төгсөгчийг Шалгалтын нэгдсэн комиссоос магистрантурт, магистрын зэрэгтэй төгсөгчийг Хамгаалуулах зөвлөлөөс докторантурт суралцах зөвлөмж өгсөн бол хугацаа харгалзахгүй элсэлтийн шалгалтгүйгээр суралцуулж болно.

3.1.9.Гадаадын иргэн суралцахыг хүсвэл Монгол улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэнэ.

## **3.2. Элсэлтийн шалгалт**

3.2.1.Элсэгчдээс уралдаант шалгалтыг мэргэжил, гадаад хэлний мэдлэгээр авна.

3.2.2.Мэргэжлийн шалгалт нийт үнэлгээний 60 хувийг, гадаад хэл 40 хувийг эзлэх ба босго оноо нь тус бүрийн 50 хувьтай тэнцэнэ.

3.2.3.Мэргэжлийн шалгалтыг тест, бодлого хосолсон хэлбэрээр авч 0-100 оноогоор дүгнэнэ. Докторантурт элсэгчийн хувьд бичиж ирүүлсэн рефератад өгөх үнэлгээ мэргэжлийн шалгалтын 50 хувьтай тэнцэнэ.

3.2.4.Гадаад хэлний шалгалтыг магистрантурт элсэгчдээс англи хэлээр, докторантурт элсэгчдээс англи, орос хэл хосолсон байдлаар тус тус бичгээр авч дүгнэнэ.

3.2.5.Шалгалтын босго оноонд хүрээгүй хүнийг элсүүлэн суралцуулахгүй.

3.2.6.Элсэлтийн шалгалтын комиссын дүгнэлт-санал, нэг дэх жилийн сургалтын төлбөрийг төлсөн байдлыг үндэслэн магистрантур, докторантурт суралцуулах тухай Цагдаагийн академийн захирлын тушаал гарснаар тухайн хүнийг зохих түвшний сургалтанд элссэнд тооцно.

### **3.3 Хичээлийн жил, улирал, сургалтын хугацаа**

3.3.1.Цагдаагийн академи магистр, докторын сургалтыг өдрийн хэлбэрээр явуулна.

3.3.2.Сургалтын норматив хугацаа магистрантурт 1.5 жил, докторантурт 3 жил байна.

3.3.3.Сургалтын хичээлийн жил 15-аас доошгүй долоо хоног бүхий 2 улирлаас тогтоно.

3.3.4.Суралцагчийн 1 улирлын ачаалал 9-12 багц цаг байна.

3.3.5.Магистр, докторын сургалт хариуцсан нэгжийн дарга суралцагчийн авьяас чадвар, мэргэжлийн бэлтгэлийг харгалзан тэнхмийн саналыг үндэслэн нэг улиралд 3 хүртэл багц цагийн хичээлийг нэмж үзэхийг зөвшөөрч болно.

3.3.6.Магистрантур, докторантурын хичээлийн улирал жил бүрийн 10, 3 сарын эхний долоо хоногийн Даваа гарагт эхэлнэ.

3.3.7.Магистрант, докторант /цаашид “Суралцагч” гэх/ нар элссэнээс хойш 1 сарын дотор сургалтын гэрээг магистр, докторын сургалт хариуцсан нэгжийн даргатай байгуулж мөрдөнө.

### **3.4 Мэдлэг, чадварыг дүгнэх**

3.4.1.Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлагыг А, В, С, D, F үнэлгээг хэрэглэн дүгнэнэ.

Үсгэн үнэлгээ нь процентон, тоон үнэлгээтэй дараах байдлаар дүйцнэ.

Үсгэн дүн	Процентон дүн	Тоон дүн
A	90-100	4.0
B	80-89	3.0
C	70-79	2.0
D	60-69	2.0
F	0-59	1

3.4.2.Хичээлийн улирлын эцэст дууссан хичээлээр хуваарийн дагуу суралцагч шалгалт өгөх ба гадаад хэлнээс бусад хичээлийн дүн “B”-ээс доошгүй байна.

3.4.3.Үнэлгээ нь энэ түвшинд хүрээгүй бол зохих бэлтгэлийг хангасны дараа зөвхөн тухайн улирлын нэг хичээлийн шалгалтыг дахин төлбөртэйгээр өгч болно.

### **3.5 Агуулга, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр**

3.5.1.Дээд боловсрол эзэмшүүлэх магистрын сургалт 30, докторын сургалт 60 багц цагаас тус тус доошгүй байна.

3.5.2.Сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөөг Академийн Эрдмийн зөвлөл, БСШУ-ны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн Академийн захирал батална.

3.5.3.Магистрын сургалтын үлгэрчилсэн (ерөнхий) төлөвлөгөө дараах бүтэцтэй байна.

д/д	Хичээлийн нэр	Багц цаг
-----	---------------	----------

1	Судалгааны арга зүй	2
2	Англи хэл	2
3	Мэргэжлийн хичээл	5
4	Мэргэших хичээл	15
5	Магистрын ажил	6
Бүгд 30 кредит		

#### 3.5.4. Докторын сургалтын үлгэрчилсэн /ерөнхий/ төлөвлөгөө дараах бүтэцтэй.

д/д	Хичээлийн нэр	Багц цаг
1	Эрдэм шинжилгээний арга зүй	3
2	Гадаад хэл	3
3	Мэргэжлийн хичээл	6
4	Мэргэшүүлэх хичээл	30
5	Эрдэм шинжилгээний ажил	6
6	Диссертац	12
Бүгд 60 кредит		

3.5.5. Шилжин ирсэн суралцагчийн бусад сургуульд судалсан хичээлээс дүйцүүлэн тооцож болох багц цагийн дээд хэмжээ магистрантурт 10, докторантурт 20 кредит байна.

3.5.6. Суралцагч хичээлийн 2-р улиралд багтаан сургалтын үлгэрчилсэн төлөвлөгөөг үндэслэн удирдагчтайгаа зөвлөн сэдвээ сонгож сургалт-судалгааны ажлын ганцаарчилсан төлөвлөгөөг боловсруулан харьяалах тэнхмээр хянуулан Академийн сургалт, эрдэм шинжилгээ эрхэлсэн тэргүүн дэд захирлаар батлуулж мөрдөнө.

3.5.7. Сургалт-судалгааны ажлын ганцаарчилсан төлөвлөгөөнд ерөнхий болон мэргэжлийн хичээлүүдийг судлах, мэргэшүүлэх хичээлийн хэлбэр, агуулгыг хэрхэн тогтоож хангах, судалгааны сэдэв, түүний бүтцийг боловсруулан батлуулах, бүлэг, хэсгийг бичих, удирдагчаараа хянуулах, зөвлөмжийн дагуу засвар хийх, мөн явуулах судалгаа, хэлэлцүүлэх эрдэм шинжилгээний илтгэл, бичиж нийтлүүлэх өгүүллийг хичээлийн улирал, сараар тодорхой тусгана.

3.5.8. Ганцаарчилсан төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг 3.5.6.-д тусгасан дараалал, журмаар шийдвэрлэх бөгөөд сургалтын хугацааны 40% өнгөрсөн тохиолдолд судалгааны сэдэв, төлөвлөгөөг өөрчлөхийг зөвшөөрөхгүй.

3.5.9. Сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийн хөтөлбөр нь уг хичээлийн зорилго, багтаамж, судлагдахуун, ашиглах ном зохиолыг заавал багтаана.

### **3.6 Магистрын сургалт**

3.6.1. Магистрын сургалтын англи хэлний хичээлийн хөтөлбөр нь хууль эрх зүйн сэдвийн хүрээнд гарсан эрдэм шинжилгээний бүтээл, нийтлэлийг уншин орчуулах, судалгаандаа авч хэрэглэх, үзэл бодлоо илэрхийлсэн эссе, өгүүллийг бичих чадвар олгоход чиглэгдэн боловсруулагдана.

3.6.2. Судалгааны арга зүй хичээлээр судалгааны аргыг ашиглах, үр дүнг тооцож боловсруулах, эрдэм шинжилгээний бүтээлийг судлах, бичих, нийтлэх, илтгэх арга зүйд суралцана.

3.6.3. Мэргэших хичээл нь суралцагчийн судалгааны чиглэлд шууд хамаарах бөгөөд агуулга нь дараах үлгэрчилсэн хэсгээс тогтоно. Үүнд:

а/ Танхимын 3-аас доошгүй багц цагийн сургалт;

б/ Сэдэв сонгосон үндэслэл, сэдвийн судлагдсан байдал, судалгааны зорилго, зорилтууд, арга зүй, шинэлэг тал, онол, практикийн ач холбогдол болон сэдвийн

бүтцийг илтгэн харуулсан рефератыг бичиж харьяалах тэнхмээр хэлэлцүүлэн зохих зөвлөмжийг тусгаснаар 2 хүртэл кредитийг хангах;

в/ Сэдвийн чиглэлээр явуулж ашиглах бүх төрлийн судалгаа, тэдгээрийн хамрах хүрээ, хугацаа, аргачлал, илрүүлэн харахыг зорьж буй дүгнэлт-үр дүнгийн талаарх төсөөллийг агуулсан рефератыг бичиж тэнхмээр хэлэлцүүлэн зөвлөмжийг тусгаснаар 2 хүртэл кредитийг хангах (Рефератад судалгаанд ашиглах судалгааны анкет, хүснэгт, санал асуулгын хуудсыг зайлшгүй хавсаргана);

г/ Харьяалах тэнхмийн эрхлэгчтэй зөвлөн багшийн удирдлага дор бакалаврын түвшний сургалтад мэргэшүүлэх чиглэлээрээ хичээл зааж 2 хүртэл кредит хангах;

д/ Сэдвийн чиглэлээр эрдэм шинжилгээний 2-оос доошгүй илтгэлийг бичиж тэнхмээр хэлэлцүүлэн кредит хангах (1 илтгэлд 1-1.5 хүртэл багц цаг олгох).

е/ Дипломын ажлаа бүхэлд нь цэгцлэн тэнхмээр хянуулан Хамгаалуулах зөвлөлийн урьдчилсан хамгаалалтын хурлаар хэлэлцүүлэхийг дэмжсэн тохиолдолд 3 хүртэл кредитийг тооцох;

### **3.7 Докторын сургалт**

3.7.1. Докторын сургалтын төлөвлөгөөн дэх эрдэм шинжилгээний арга зүй хичээл хэд хэдэн хичээлээс бүрдэх бөгөөд агуулгад нь тоон, чанарын судалгааны арга зүйн асуудлуудыг заавал тусгана.

3.7.2. Гадаад хэлний хичээлийн төрлийг докторант өөрөө сонгох ба хөтөлбөрийн агуулга нь магистрын сургалтаас ахисан түвшинд боловсруулагдана.

3.7.3. Мэргэшүүлэх хичээл нь докторантын диссертацийн судалгааны чиглэлд хамаарах бөгөөд агуулга нь дараах үлгэрчилсэн хэсгээс тогтоно. Үүнд:

а/ Танхимын 3-аас доошгүй багц цагийн сургалт;

б/ Сэдэв сонгосон үндэслэл, сэдвийн судлагдсан байдал, судалгааны зорилго, зорилтууд, арга зүй, шинэлэг тал, онол, практикийн ач холбогдол болон сэдвийн бүтцийг илтгэн харуулсан рефератыг бичиж харьяалах тэнхмээр хэлэлцүүлэн зохих зөвлөмжийг тусгаснаар 3 хүртэл кредитийг хангах;

в/ Сэдвийн чиглэлээр явуулж ашиглах бүх төрлийн судалгаа, тэдгээрийн хамрах хүрээ, хугацаа, аргачлал, илрүүлэн харахыг зорьж буй дүгнэлт-үр дүнгийн талаарх төсөөллийг агуулсан рефератыг бичиж тэнхмээр хэлэлцүүлэн зөвлөмжийг тусгаснаар 2 хүртэл кредитийг хангах (Рефератад судалгаанд ашиглах судалгааны анкет, хүснэгт, санал асуулгын хуудсыг зайлшгүй хавсаргана);

г/ Харьяалах тэнхмийн эрхлэгчтэй зөвлөн багшийн удирдлага дор бакалавр, магистрын түвшний сургалтад мэргэшүүлэх чиглэлээрээ хичээл зааж 3 хүртэл кредит хангах;

д/ Судалгааны чиглэлээр 6-аас доошгүй эрдэм шинжилгээний илтгэл боловсруулан академийн Судалгааны семинарын зөвлөлөөр хэлэлцүүлэн 18 хүртэл кредит хангах;

Тайлбар: Их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллага, яам, агентлагын хэмжээнд болон улс, олон улсын шинж чанартай эрдэм шинжилгээний хуралд тавьж хэлэлцүүлсэн илтгэлийг хэрхэн үнэлэн тооцох асуудлыг Судалгааны семинарын журамд нарийвчлан тусгана.

е/ Диссертацийн ажлыг бүхэлд нь цэгцлэн тэнхмээр хянуулан академийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж дүгнэлт гаргавал 4 хүртэл кредитийг тус тус тооцож болно.

3.7.4. Докторантын сургалтын төлөвлөгөөн дэх эрдэм шинжилгээний ажил нь түүнээс диссертацийн чиглэлээр бичиж реценз бүхий мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлсэн 2-оос цөөнгүй эрдэм шинжилгээний өгүүллээр тооцогдоно.

### **3.8. Гадаад хэлний болон нэгдсэн шалгалт**

3.8.1.Магистрант нийт судлах хичээлийн 2/3-ийг үзсэний дараа англи хэлний шалгалтыг өгнө. Энэ шалгалтыг 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй комисс авна.

3.8.2.Докторантын хувьд хичээлээр авах нийт багц цагийг хангасны дараа гадаад хэлний болон мэргэжил, мэргэших чиглэлээрх мэдлэг, диссертац бичихэд шаардлагатай бие даасан судалгаа явуулах чадварыг нотлох зорилго бүхий нэгдсэн шалгалтыг тус тус өгнө.

Эдгээр шалгалтыг мөн 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй комисс авна.

3.8.3.Гадаад хэлний шалгалтыг суралцагчийн судалсан хичээлээр авч 75, түүнээс дээш үнэлгээтэй тохиолдолд хангалттайд тооцно.

3.8.4.Энэ үнэлгээг хангаж чадаагүй суралцагч зохих сургалтад хамрагдсаны дараа дахин шалгалт өгнө. Энэ нь сургалтын хугацаа, багтаамж, төлбөрт тооцогдохгүй.

### **Дөрөв.Судалгааны ажлын төлөвлөгөө**

4.1.Магистрант нийт судлах хичээлийн 2/3-ыг үзсэний дараа, докторант нийт шалгалтуудаа өгснөөр удирдагч, харъяалах тэнхимтэй зөвлөн дипломын ажил, диссертацын сэдэв, сэдвийн бүтэц, судалгааны ажлын төлөвлөгөөг илтгэн харуулсан рефератыг бичиж Академийн судалгааны семинарын зөвлөлөөр хэлэлцүүлэн тодотгож Захирлын тушаалаар баталгаажуулна.

4.2.Сэдэв, ач холбогдлын хувьд судлах шаардлагатай ч реферат муу бичигдсэн, эсвэл суралцагч түүнийгээ илтгэн хамгаалж чадаагүй бол дахин нэг удаа Эрдмийн зөвлөлөөс байгуулсан комиссоор хэлэлцүүлж болно. Харин энэ комисст сэдвээ хамгаалж чадаагүй суралцагч улирах буюу хасагдана.

4.3.Судалгааны ажлын төлөвлөгөө нь энэ журмын 3.5.6-д заасан сургалт-судалгааны ажлын төлөвлөгөөтэй нэг байна.

### **Тав. Магистрын ажил, докторын диссертаци**

5.1.Магистрын ажлыг Академийн магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлд хамгаалуулна.

5.2.Зөвлөлийг байгуулах болон үйл ажиллагааных нь журмыг БСШУ-ны сайдын 2007 оны 187-р тушаалын 3-р хавсралтаар батлагдсан “Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”-д нийцүүлэн Академийн захирлын тушаалаар тогтооно.

5.3.Магистрын ажилд дараах шаардлага тавигдана. Үүнд:

а/ Агуулгын хувьд:

-сэдэв, судалгааны хүрээ, дүгнэлт, санал нь энэ чиглэлээр өмнө нь бичигдсэн бүтээлүүдээс ялгаран, онол практикийн хувьд тулгамдаж буй тодорхой асуудлуудыг шийдвэрлэх арга замыг тодорхойлсон байх

-дэвшүүлж, нотлож буй дүгнэлт санал нь судалгаа, бодит баримт, онол, арга зүйд тулгуурласан, практикт нэвтрүүлэх боломжтой байхын зэрэгцээ өмнө мэдэгдэж буй шийдлүүдтэй харьцуулан шинэлэг, давуу талыг нь нээн харуулсан байх

б/ Хэлбэрийн шаардлага:

-дипломын ажил хавсралт, ном зүйг оруулалгүйгээр 60-80, хураангуй 10-12 хуудснаас бүрдэнэ. Хураангуйд уг ажлын үндсэн агуулгыг бүлэг, хэсгээр товч дурьдаж, нээсэн, тогтоосон үр дүн, дэвшүүлсэн дүгнэлт санал, судалгааны шинэлэг тал, ач холбогдлыг бичнэ. Мөн судалгаатай холбогдуулан бичиж нийтлүүлсэн, эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн бүтээлийн жагсаалтыг тусгана.

5.4.Академийн Эрдмийн зөвлөлөөр докторантын диссертацийг хэлэлцэн дүгнэлт шийдвэр гаргахын тулд суралцагч дараах шаардлагыг хангасан байна.

а/ сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийн кредитийг бүрэн хангасан тухай магистр, докторын сургалт хариуцсан нэгжийн даргын тодорхойлолт;

б/ диссертацийг тэнхмээр хянуулан Академийн Эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхийг дэмжсэн удирдагчийн тодорхойлолт, харъяа тэнхмийн хурлын тэмдэглэл-шийдвэр.

5.5.Диссертацид тавигдах шаардлага нь БСШУ-ны сайдын 2007 оны 187-р тушаалын 1-р хавсралтын 16-д заасан шаардлагатай адил байна.

5.6.Магистрын ажил, диссертацийн ном зүйн хэсэгт зөвхөн уг ажилд иш татсан бүтээлийг тусгана. Ашигласан материал буюу тодорхой үр дүнгийн зохиогч, эх сурвалжийг заавал иш татна.

### **Зургаа. Судалгааны дүнг хэвлүүлэх**

6.1.Докторант судалгааны ажлын төлөвлөгөөний дагуу хийсэн диссертацид хамаарах 2-оос доошгүй эрдэм шинжилгээний өгүүллийг реценз бүхий мэргэжлийн сэтгүүлд заавал хэвлүүлнэ.

6.2.Магистрантын хувьд энэ нь нэг өгүүлэл байна.

### **Долоо. Анги дэвших, тодорхойлолт олгох, чөлөө авах, Академиас хасах**

7.1.Хичээлийн тухайн улирлын сургалт, судалгааны ажлын төлөвлөгөөг бүрэн биелүүлж, сургалтын төлбөрийг төлсөн суралцагчийг магистр, докторын сургалт хариуцсан албаны даргын шийдвэрээр дараагийн улирлын сургалтад дэвшүүлэн суралцуулна.

7.2.Сурлагын кредитээ биелүүлсэн боловч дипломын ажлаа хүндэтгэх шалтгааны улмаас хугацаандаа хийж дуусгаагүй, мөн амжилтгүй хамгаалсан магистрантын дипломын ажил хамгаалах хугацааг 1 удаа 0.5-1 жилээр сунгаж болно. Энэ тохиолдолд сургалтын төлбөрийг нэмж авна.

7.3.Дипломын ажлаа 2 дах удаагаа амжилттай хамгаалж чадаагүй магистрантад сургалт дүүргэсэн тодорхойлолт олгоно.

7.4.Сургалттай холбоотой бүх кредитээ норматив хугацаанд хангасан боловч хүндэтгэн үзэх шалтгаанаар Эрдэм шинжилгээний ажлын 6 кредит болон диссертация бичиж Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлээгүй докторантад тэнхмийн саналыг үндэслэн энэ ажлаа гүйцээх 1 хүртэл жилийн хугацаат үүрэг өгч болно.

7.5.Эрдмийн зөвлөлийн хурлаар диссертациа хэлэлцүүлсэн боловч дэмжигдээгүй докторантад ажлаа цэгцлэн дахин 1 удаа 1.5 жилийн дотор Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэх эрх олгоно.

7.6.Эдгээр хугацаанд хэлэлцүүлээгүй болон дахин хэлэлцсэн боловч ажил нь дэмжигдээгүй докторантад Цагдаагийн академийн докторын сургалтанд суралцсан тухай тодорхойлолт олгоно.

7.7.Хүндэтгэх шалтгааны улмаас суралцах боломжгүй болж Академийн захиргаанд хандан чөлөө хүссэн суралцагчид 1 жилийн чөлөө олгоно. Докторантад энэ чөлөөг дахин нэг удаа олгож болно.

7.8.Хичээлийн 1 дүгээр улирлаас хойшхи хугацаанд дараагийн шатны сургалтын төлбөрөө төлөх боломжгүй суралцагч 1 удаа жилийн чөлөө авч болно.

7.9.Академиас суралцагчийг дараах үндэслэлээр хасна. Үүнд:

а/ Сургалтын төлбөр барагдуулаагүйн улмаас 1 жилийн чөлөө авсны дараагийн жил ирээгүй бол;

б/ Албан ёсоор мэдэгдэлгүй, хүндэтгэх шалтгаангүйгээр 40-өөс дээш цагийн сургалтад оролцоогүй бол;

в/ Нэг улирлын 2 шалгалтыг амжилтгүй өгсөн ба дахин шалгалтад хангалтгүй дүн үзүүлсэн бол;

г/ 4.2, 7.6-д заасан нөхцөлд.

### **Найм. Докторантурт суралцсан гэрчилгээ, магистрын зэрэг олгох шийдвэр гаргах**

8.1. Академийн Эрдмийн зөвлөлөөр хянагдан дэмжигдсэн докторантын диссертацийн ажлыг Докторантурын хороонд холбогдох материалын хамт хүргүүлнэ. Энэ тохиолдолд докторантад сургалт дүүргэсэн гэрчилгээ олгоно.

8.2. Магистрант зохих шаардлагыг ханган, бүрэн эцэслэсэн дипломын ажлын 3 хувь дээр удирдагч, хамгаалуулах зөвлөлийн гишүүдээр гарын үсэг зуруулж магистр, докторын сургалтын албанд өгнө.

Энэ албанаас дипломын ажлыг мөн электрон хувилбараар авч болно.

8.3. Энэ журмын 3.4.2, 3.6, 3.8.3, 8.2-д заасан шаардлагыг бүрэн хангасан магистрантад Академийн захирлын тушаалаар магистрын зэрэг олгохоор шийдвэрлэнэ.

### **Ес. Бусад зүйл**

Магистр, докторын сургалтын төлбөрийн хэмжээг Цагдаагийн академийн санхүүгийн албаны саналыг үндэслэн захирлын тушаалаар жил бүр шинэчлэн тогтоож болно.

Цагдаагийн академийн Эрдмийн зөвлөлийн 2007.11.08-ны өдрийн хурлаар хэлэлцэж зөвшөөрөв.

**ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС**